



**НИЙСЛЭЛИЙН  
СПОРТЫН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/67

Улаанбаатар хот

┌ Тооллогын комисс байгуулж, ┐  
байгууллагын эд хөрөнгийн тооллого  
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 439 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 136 дугаар тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 273 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус байгууллагын 2019 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгө, материалын тооллого явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үүнд:

Тооллогын комиссын дарга  
Нарийн бичиг  
Гишүүд

С.Саранцэцэг /Хэлтсийн дарга/  
Б.Оюунтуяа /Мэргэжилтэн/  
Э.Мөнх-Эрдэнэ /Мэргэжилтэн/  
Г.Бямбасайхан /Мэргэжилтэн/  
Н.Өлзийжаргал /Мэргэжилтэн/

2. Тооллогыг 2019 оны 12 дугаар сарын 09-13-ны өдрүүдэд зохион байгуулж, 2019 оны 12 дугаар сарын 13-ны дотор байгууллагын даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг тооллогын комиссын хэлтсийн дарга С.Саранцэцэгт даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500220

Нийслэлийн Спортын хорооны даргын  
2019 оны *арванхоёрдугаар* сарын 06-ны  
өдрийн *№7* дугаар тушаалын хавсралт



Тооллого явуулах хуваарь

д/д	Тооллого хийх газрууд	Хуваарьт өдрүүд	тайлбайн
1.	Нийслэлийн Спортын хорооны өрөө тасалгаануудын эд хогшил техник хэрэгсэлийг тоолох	2019.12.11-нд	Тооллогын комиссын гишүүд нийтээр оролцоно.
2.	Тооллогын дүнг нэгтгэх, холбогдох байгууллагад хүргүүлэх ажил	2019.12.12-13-нд	Тооллогын комиссын гишүүд нийтээр оролцоно.